



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАР
УЛСЫН БАЙЦААГЧИЙН
АКТ

Хуульчдын гудамж 13/1
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 32 80 30, Факс: (976-11) 32 07 16,
Цахим шуудан: undeg@ndaatgal.mn
Цахим хуудас: www.ndaatgal.mn

2024.05.31 № 32/11

Дутуу олгосон тэтгэврийг
нөхөн олгох тухай

Монгол улсын Засгийн газрын 2023 оны 420 дугаар тогтоолоор баталсан "Салбарын хяналт шалгалтын 2024 оны төлөвлөгөө, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яамны Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2024 оны 02 дугаар сарын 07-ний өдрийн 13-07/08 тоот "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай" удирдамжийн хүрээнд Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын газарт Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5³ дугаар зүйлийн 5³.1, 5³.2-т тус тус заасны дагуу Нийгмийн даатгалын байгууллагын Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 2021-2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнд Төрийн хяналт шалгалтын тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж төлбөрийн тухай хууль, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2017 оны 10 дугаар тогтоолоор баталсан "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлыг санхүүжүүлэх журам болон бусад холбогдох дүрэм, журмын хэрэгжилт нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэлт, зарцуулалтад холбогдох баримт материал тэтгэврийн хувийн хэрэг болон цахим программд тулгуурлан 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдрөөс эхлэн 05 дугаар сарын 01-ний өдрүүдэд хяналт шалгалт хийлээ.

Шалгалтаар Баянзүрх дүүргийн 2 дугаар хорооны иргэн Ц.Амарбаясгалан (рд:УК88090974) нь 2013 оны 03 дугаар сарын 21-ний өдрөөс Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн дагуу тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгохоор Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст хандахад эрх үүсэхгүй тодорхойлолт өгч Нийгмийн Халамжийн сангаас тэтгэвэр тогтоолгосон ба 2013 оны 10-р сараас эхлэн 2019 оны 11-р сарын хооронд Нийгмийн Халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу нийт 10.085.716 (арван сая наян таван мянга долоон зуун арван зургаа) төгрөгийн тэтгэвэр авсан байна. Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн дагуу тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгосон бол 18.357.167 (арван найман сая гурван зуун тавин долоон мянга нэг зуун жаран долоо) төгрөгийн тэтгэвэр авах байсан бөгөөд 8.278.451 (найман сая хоёр зуун далан найман мянга дөрвөн зуун тавин нэг) төгрөгийн тэтгэврийг дутуу олгосон нь Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх "Даатгуулагч үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа удаан хугацаагаар буюу байнга алдаж тахир дутуу болсон бол тахир дутуугийн тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй" заалтыг зөрчсөн байна.

Нийгмийн даатгалын сангаас олгох Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн дагуу 2019 оны 12-р сараас тогтоосон

1524060048

тэтгэвэр нь Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн 238, 239 дугаар тогтоолоор итгэлцүүр өөрчлөгдөн, 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 120 дугаар тогтоолоор тэтгэврийн хэмжээ нэмэгдэж 2.465.067 (хоёр сая дөрвөн зуун жаран таван мянга жаран долоо) төгрөгийг илүү олгосон байна. Тухайн иргэнд нийтдээ 5.806.384 (таван сая найман зуун зургаан мянга гурван зуун наян дөрөв) төгрөгийг дутуу олгосон байна.

Иймд Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.9.13 "Хууль тогтоомжид заасан бүрэн эрх"-т, Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 "Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг Засгийн газар, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл, бүх шатны Засаг дарга, хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ" гэх заалтыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас дутуу олгосон 5.806.384 (таван сая найман зуун зургаан мянга гурван зуун наян дөрөв) төгрөгийг 2024 оны 09 сарын 15-ны өдрийн дотор төлж барагдуулахыг Газрын дарга Ш.Ариунтуяа, Санхүү бүртгэлийн тасгийн дарга, ахлах нягтлан бодогч О.Сайнзаяа, Үйлчилгээний тасгийн дарга Д.Гэрэлцэцэг, сангийн нягтлан бодогч Л.Энхцэцэг нарт хариуцуулав.
2. Улсын байцаагчийн актын дагуу холбогдох арга хэмжээг авч, биелэлтийг гарган баримтын хамт Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын хяналтын газарт 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлэхийг мэдэгдье.
3. Дээр дурдсан хугацаанд биелүүлээгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан сахилгын шийтгэл ногдуулах саналыг эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэх болохыг мэдэгдье.
4. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасны дагуу гомдол гаргах эрхтэй.

АКТ ТОГТООСОН:

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ  М.АМАРЗАЯА

НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ  А.МИЧИДМАА

ХҮЛЭЭН АВСАН:

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ГАЗРЫН ДАРГА  Ш.АРИУНТУЯА 2024.10.07

САНХҮҮ, БҮРТГЭЛИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА  О.САЙНЗАЯА

ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА  Д.ГЭРЭЛЦЭЦЭГ
2024.10.07.

Тайлбар.....
.....
.....